



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 138

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө  
бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Өвөрхангай аймгийн Засаг даргын 2019 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн А/475 дугаар захирамж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Өвөрхангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 40,000,000.00 (дөчин сая) төгрөгийн балансын үнэ бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн автомашиныг хавсралтад заасны дагуу төрийн өмчид хүлээн авч Өвөрхангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн үндсэн хөрөнгөдөө бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Стандарт, хэмжил зүйн газрын дарга Б.Билгүүн, Өвөрхангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга Г.Мөнхтөр, Өвөрхангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Н.Ганболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;


2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




З.МЭНДСАЙХАН

Д.НАРАНГЭРЭЛ

000209

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 04 дугаар сарын 21 өдрийн  
138 дугаар тогтоолын хавсралт



Өвөрхангай аймгийн Орон нутгийн өмчийн газраас  
Өвөрхангай аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэст  
балансаас балансад шилжих автомашин

Д/д	Автомашин нэр, марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн / ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	суудлын машин Лексус 470, улсын дугаар 0070 ӨВР, арал JTJNTOOW723521424	2002/2013	116,898	40,000,000.00	40,000,000.00	0
	Нийт дүн			/Дөчин сая /	/Дөчин сая /	